




ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖ НЭМЭГДСЭН БАЙНА.

АУДИТЫН СЭДЭВ: ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛ, ҮР ДҮНД СУУРИЛСАН
САНХҮҮЖИЛТИЙН ТОГТОЛЦОО, ҮР НӨЛӨӨ

АУДИТЫН КОД: ОРА-2023/19-5-ШТА-ГА



Орхон аймаг
2023 он

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах

Утас: 70353888 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn

Аудитын менежер Б.Буян-Ундрах

Утас: 70355805 Цахим хаяг: buyanundrakhb@audit.gov.mn

Ахлах аудитор Г.Оргилмөрөн

Утас: 70357955 Цахим хаяг: orgilmurung@audit.gov.mn

Аудитор Б.Азжаргал

Утас: 70350757 Цахим хаяг: azjargalb@audit.gov.mn

Аудитор Ж.Наранчимэг

Утас: 70359826 Цахим хаяг: naranchimegj@audit.gov.mn

Аудитор О.Гантуяа

Утас: 70355805 Цахим хаяг: gantuyao@audit.gov.mn

Аудитор Ж.Цэнгэлмаа

Утас: 70357955 Цахим хаяг: tsengelmaaj@audit.gov.mn



**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ**

2023 оны 05 сарын 19 өдөр

Дугаар 4/09

Эрдэнэт

**Аудитын тайланг баталгаажуулах
тухай**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.4, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2018 оны А/207 дугаар тушаалаар баталсан “Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт шилжүүлэх бүрэн эрх, үүрэг”-ийн 2.4 дэх хэсэг, “Төрийн аудитын байгууллагын аудит хийх журам”-ын 18.9 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөө” гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай.
2. Аудитаар тогтоосон төлбөрийн актын жагсаалтыг хавсралтаар баталсугай.
3. Аудитын тайланг Үндэсний аудитын газар, аймгийн Эрүүл мэндийн газар, Эрүүл мэндийн даатгалын хэлтэст тус тус хүргүүлсүгэй.
4. Аудитын тайланд дурдагдсан зөрчлүүдийг арилгахаар өгсөн зөвлөмж, тогтоосон төлбөрийн актыг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2023 оны 11 дүгээр сарын 20-ний өдрийн дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн дарга /Д.Чимгээ/-д зөвлөсүгэй.
5. Аудитын тайлангаар өгсөн төлбөрийн акт, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2023 оны 4 дүгээр улиралд гарган танилцуулахыг аудитын менежер Б.Буян-Ундрах, ахлах аудитор Г.Оргилмөрөн, аудитор О.Гантуяа, Б.Азжаргал, Ж.Наранчимэг нарт даалгасугай.

ДАРГА, БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРМАНДАХ

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар	3
Хүснэгтийн товъёг.....	3
Ерөнхий мэдээлэл	5
Нэг. Эрүүл мэндийн даатгалын сан, тусламж үйлчилгээтэй холбоотой тогтолцооны шинэчлэлтийг Монгол Улсын хөгжлийн бодлогод тусгасан зорилтын хүрээнд зохион байгуулж байна.....	7
A1.1. Монгол Улсын хөгжлийн бодлогын урт, дунд болон богино хугацааны баримт бичгүүдэд эрүүл мэндийн даатгалын талаар тусгасан зорилтыг хангах арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлж байна.....	7
A1.2. Эрүүл мэндийн даатгалын үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог үр дүнтэй зохион байгуулж байна.	8
Хоёр. Төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын орлого нэмэгдэж, тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж сайжирсан байна.	9
B1.1. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого, хамрагдалтын төлөвлөгөөг бодит гүйцэтгэлд үндэслэж батлаагүй, биелэлтийг бүрэн хангаж ажиллаагүй байна.....	9
B1.2. Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтийг хянаж, гүйцэтгэлийг тайлагнаж байна.....	10
B1.3. ЭМДЕГ-аас эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагатай даатгалын гэрээ байгуулж, гүйцэтгэлийг дүгнэж байна.....	11
B1.4. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж буй төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудад олгосон санхүүжилт үр нөлөөтэй байна.	12
B2.1. Эрүүл мэндийн байгууллагаас эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байгаа хүн амыг тусламж үйлчилгээнд хамруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр ажил зохион байгуулаагүй байна.	13
B2.2. Эрүүл мэндийн даатгалын үйлчилгээнд даатгуулагч, эмнэлэг, эмийн сан, даатгалын байгууллага болон бусад төрийн байгууллагыг холбосон найдвартай цахим мэдээллийн системийг үе шаттай хөгжүүлж байна.	15
B2.3. Эрүүл мэндийн даатгалын байгууллага нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээний талаар даатгуулагчдад шаардлагатай мэдээллийг цахим мэдээллийн хэрэгслээр хүргэж байгаа хэдий ч хүртээмж хангалтгүй байна.	16
B3.1. Бодлогын баримт бичигт тусгасан зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд хууль хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг тооцсон байна.....	18
B3.2. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар болон төлбөрийн хяналтыг дэлгэрэнгүй тайланг эрүүл мэндийн байгууллагад илгээх, эргэх холбоо тогтоох, иргэн даатгуулагчийг холбогдох мэдээллээр хангах асуудал дутмаг байна.	19
B3.3. ЭМДЕГ-аас болон ЭМДХ нь хяналт, шалгалтыг журмын дагуу хэрэгжүүлж байна. .	22
B3.4. Шилэн дансны тухай болон Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт нь ЭМДЕГ-т хамааралтай байна.....	25
Холбогдох байгууллагын санал:	26
Дүгнэлт:.....	28
Зөвлөмж:	28
Санал:	28
Хавсралт:.....	29

Товчилсон үгийн тайлбар

УИХ	Улсын Их Хурал
МУЕА	Монгол улсын Ерөнхий Аудитор
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ЭМДҮЗ	Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл
ЭМДЕГ	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
ЭМТ	Эрүүл мэндийн төв
БОЭТ	Бүсийн оношилгоо эмчилгээний төв
ЭМДХ	Эрүүл мэндийн даатгалын хэлтэс
ЭМБ	Эрүүл мэндийн байгууллага
АШЭМБ	Анхан шатны эрүүл мэндийн байгууллага
ӨЭМТ	Өрхийн эрүүл мэндийн төв
НҮЭМ	Нийгмийн үндэсний эрүүл мэнд
ХХЭМБ	Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага

Хүснэгтийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
1	Хамрагдалтын төлөвлөгөөнд төлөвлөсөн болон хамрагдсан иргэд	9
2	ЭМДС-аас 2021,2022 онд олгосон санхүүжилт	10
3	Коронавируст халдвараар өвчилж, эмчлүүлсэн даатгуулагчийн хүндийн зэргийг ахиулж нэхэмжилж, илүү санхүүжилт авсан ЭМБ-ын жагсаалт.	11
4	ЭМБ-д хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ авсан даатгуулагчийн тоо	13
5	Орхон аймгийн ӨЭМТ-ийн 1 эмчид ногдох иргэдийн тоо	15
6	ЭМДЕГ-аас ӨЭМТ-д хүргүүлсэн төлбөрийн актын дүн	23
7	ЭМДЕГ-аас хувийн хэвшлийн ЭМБ-д хүргүүлсэн төлбөрийн актын дүн	24
8	ЭМДЕГ-аас БОЭТ-д хийсэн шалгалтаар илэрсэн зөрчлийн дүн	24

Дүрслэлийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
1	Орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл	9
2	Арван мянган хүн тутамд ногдох эмч, сувилагч, орны тоо	12
3	Нэг эмч, сувилагчид ногдох хүний тоо	12
4	Хүн амын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамрагдсан байдал	14
5	Иргэдээс авсан санал асуулгын дүн.	16
6	Өргөдөл гомдлын шийдвэрлэлт	17
7	Иргэдийн санал асуулга	17
8	Хэлтсийн албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт	19

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ, АРГА ЗҮЙН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ	
Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитыг УИХ-ын Төсвийн байнгын хорооны “Аудитын сэдэв батлах тухай” 2022 оны 09 дүгээр тогтоол, МҮЕА-ын 2023 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-г тус тус үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийж гүйцэтгэв.
Аудитын зорилт	“Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөө” сэдвээр улсын хэмжээнд нэгдсэн удирдамжаар гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулж, УИХ болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэсэн. Аудитын зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд: - Эрүүл мэндийн даатгалын тогтолцоо, үйл ажиллагааны үр дүн, бодлогын баримт бичгийн хэрэгжилт хангагдсан эсэх; - Эрүүл мэндийн байгууллагаас даатгуулагчийн эрэлт, хэрэгцээ, шаардлагад нийцсэн эрүүл мэндийн чанартай тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа эсэх;
Аудитын хамарсан хүрээ	Аудитад Орхон аймгийн Эрүүл мэндийн газар, Эрүүл мэндийн даатгалын хэлтэс, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлдэг төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд, өрх, сумын эрүүл мэндийн төвүүд, Нийгмийн даатгалын хэлтсийн 2021-2022 оны үйл ажиллагааг хамрууллаа.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 3000-3100, Гүйцэтгэлийн аудитын үндсэн ойлголтын удирдамж УДИР 3910, УДИР 3920, Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, МҮЕА-ын баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”-ын дагуу шалгагдагч байгууллагын холбогдох албан тушаалтнуудаас тайлбар, тодруулга, судалгаа авч, шаардлагатай баримт материалд дүн шинжилгээ хийж, аудитын асуудлын шинжилгээ, аудитын загварын матриц, аудитын горимыг хэрэгжүүлэн нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021, 2022 оны 01,02,05,06,11,12-р тогтоолуудыг шалгуур үзүүлэлт болгон ашигласан. Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах удирдаж, аудитын менежер Б.Буян-Ундрах чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Г.Оргилмөрөн, аудитор Б.Азжаргал, Ж.Наранчимэг, О.Гантуяа, Ж.Цэнгэлмаа нар 2023 оны 04 дүгээр сарын 01-ны өдрөөс эхлэн 2023 оны 05 дугаар сарын 19-ний өдөр хүртэлх хугацаанд гүйцэтгэв.
Аудитын явцад учирсан хүндрэл, бэрхшээлүүд:	Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн дарга ажлаас чөлөөлөгдөхдөө дараагийн хүндээ баримт материалаа бүрэн хүлээлгэж өгөөгүйгээс шаардлагатай мэдээлэл байхгүй аудитад хүндрэл учирч байсан.

Ерөнхий мэдээлэл

УИХ-аас Эрүүл мэндийн даатгалын тухай, Эрүүл мэндийн тухай, Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хуульд 2020 оны 08 дугаар сарын 18-ны өдөр оруулсан нэмэлт өөрчлөлтөөр Эрүүл мэндийн даатгалын хууль, эрх зүйн орчин шинэчлэгдэж, иргэд эрүүл мэндийн даатгалд бүрэн хамрагдах, эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх тусламж, үйлчилгээний төлбөрийн тариф, оновчтой болгох ажлууд хэрэгжиж эхэлсэн байна.

Эрүүл мэндийн салбарт 2020 оноос хэрэгжиж байгаа санхүүжилтийн шинэчлэлийн хүрээнд Монгол Улс нэг худалдан авагчийн тогтолцоонд шилжиж, эрүүл мэндийн даатгалын санд төрөөс төлбөрийг нь хариуцах тусламж, үйлчилгээний зардал нэмэгдэн орж ирсэн.

Эрүүл мэндийн даатгалын сангаас эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авах стратегийн худалдан авалтын үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэх, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын институтын чадавхыг бэхжүүлэх шинэчлэлийг амжилттай хэрэгжүүлэх, улмаар бүх нийтийн эрүүл мэндийн хамралтад хүрэх нь чухал ач холбогдолтой юм.

Шинэчлэлийг хэрэгжүүлснээр Эрүүл мэндийн байгууллагууд нь даатгуулагчид үзүүлсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, үр дүнд үндэслэн “гүйцэтгэлээр” санхүүжилтээ авах боломж бүрдсэн.

Тогтолцооны шинэчлэлтэй холбоотой журмуудыг батлан хэрэгжүүлж, хэрэгжилтэд тулгамдаж байгаа асуудлууд, хэрэгжилтийн үр нөлөөнд дүн шинжилгээ хийж, эдийн засгийн нөхцөл байдлаас үүдэлтэй үнийн болон цалингийн өсөлт зэргийг үндэслэн холбогдох өөрчлөлтийг оруулан шинэчлэн боловсруулж, батлан хэрэгжүүлж байна.

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлөөс 2022 онд дараах тогтоолуудыг шинэчлэн батлан, хэрэгжүүлж байна. Үүнд:

- Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай 2022 оны 01-р тогтоол,
- Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулах журам 2022 оны 02-р тогтоол,
- Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай 2022 оны 05-р тогтоол
- Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн багц, төлбөрийн хэмжээ, журам батлах тухай 2022 оны 06-р тогтоол
- Эмийн жагсаалт шинэчлэн батлах тухай 2022 оны 11-р тогтоол
- Журам батлах тухай /Чанар төлбөрийн хяналтын журам/ 2022 оны 12-р тогтоол.

Орхон аймагт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын ЭМДЕГ-тай гэрээ байгуулсан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний мэдээлэл.



Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд 2017 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр орсон нэмэлт өөрчлөлтөөр Эрүүл мэндийн даатгалын асуудал хариуцсан Төрийн захиргааны байгууллага бие даасан статустай ажиллахаар тогтож, Засгийн газрын 2017 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн “Агентлаг байгуулах тухай” 344 дүгээр тогтоолоор Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрыг байгуулсан. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл (ЭМДҮЗ) -ийн 2017 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 03 дугаар тогтоолоор тус агентлагийн бүтэц, дүрмийг баталж, 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн байна.

Эрүүл мэндийн даатгалын байгууллага нь даатгуулагчийн хуулиар олгогдсон эрүүл мэндийн жигд, хүртээмжтэй, чанартай тусламж, үйлчилгээ авах эрхийг эдлүүлэх, төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогод тусгасан бүх нийтийг эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хамруулан хэнийг ч орхигдуулахгүй байх, эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд шууд төлөх төлбөрийн хэмжээг бууруулах зорилтод нийцүүлэн эрүүл мэндийн даатгалын бодлого үйл ажиллагааг явуулж байна.

Эрүүл мэндийн даатгалын сан, тусламж үйлчилгээтэй холбоотой “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогод 6 асуудал, Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд 2 асуудал, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт 9 асуудал тус тус тусгагдсан байна.

ЭМДЕГ нь дээрх хөгжлийн бодлогуудад тусгагдсан асуудлыг нэгтгэн 2022 оны 12 дугаар сарын 05-нд Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын 2023-2026 оны стратеги төлөвлөгөөг батлан, мөрдөн ажиллаж байна.

НЭГ. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САН, ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭТЭЙ ХОЛБООТОЙ ТОГТОЛЦООНЫ ШИНЭЧЛЭЛТИЙГ МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГОД ТУСГАСАН ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД ЗОХИОН БАЙГУУЛЖ БАЙНА.

А1.1. Монгол Улсын хөгжлийн бодлогын урт, дунд болон богино хугацааны баримт бичгүүд болон аймгийн хөгжлийн бодлогод эрүүл мэндийн даатгалын талаар тусгасан зорилтыг хангах арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлж байна.

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”-д эрүүл мэндийн даатгалын сан, тусламж үйлчилгээтэй холбоотой 6 зорилт, арга хэмжээ, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд 2 зорилт, арга хэмжээ, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт 9 зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхээр заасан байна.

Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд эрүүл мэндийн чиглэлээр 5 зорилтын хүрээнд 25 арга хэмжээ, Орхон аймаг, Эрдэнэт хотын 2021 оны хөгжлийн төлөвлөгөөний ерөнхий зорилтын 2-т “Эрүүл бүтээлч, хөгжих тэмүүлэлтэй эрдэнэт хүн” зорилтын хүрээнд 13 арга хэмжээ, Орхон аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, хянах тогтолцоог бэхжүүлж, орчин үеийн оношилгоо, эмчилгээний технологийг өргөжүүлэх замаар эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилтын хүрээнд 10 арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр тус бүр тусган хэрэгжүүлж ажилласан байна.

1. Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, иргэн бүр урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд тогтмол хамрагдах нөхцөлийг сайжруулж, нотолгоонд суурилсан эрүүл мэндийг дэмжих бодлогыг хэрэгжүүлнэ.
2. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх замаар сэргийлж болох өвчлөл, нас баралтыг бууруулна.
3. Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн эрүүл мэндийн байгууллагын бэлэн байдал, хариу арга хэмжээ авах чадавхыг бэхжүүлнэ.
4. Эрүүл мэндийн салбарт цахим үйлчилгээг өргөжүүлэн, эрүүл мэндийн мэдээллийн сан бүрдэн, орон нутагт хийгдэх оношилгоо эмчилгээнд алсын зайн технологи ашиглаж, цахим эрт илрүүлэг, эргэн дуудах үйлчилгээг нэвтрүүлнэ.
5. Эрүүл мэндийн ажилтны ур чадвараа тасралтгүй хөгжүүлэх боломжийг нэмэгдүүлж, нийгмийн баталгааг сайжруулах хөтөлбөр хэрэгжүүлэн, тэдний эрүүл аюулгүй тав тухтай ажиллаж, амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.

Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, иргэн бүр урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд тогтмол хамрагдах нөхцөлийг сайжруулж, нотолгоонд суурилсан эрүүл мэндийг дэмжих бодлогыг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн харьяа Эрүүл мэндийг дэмжих төвд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаас нийт 2.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийснээс орон нутгаас их засварын ажилд 289.0 сая төгрөг, улсын төсвөөс их засварт 180.0 сая төгрөг, тоног төхөөрөмжид 1.5 тэрбум төгрөгийн үзлэг шинжилгээ болон оношилгооны 34 нэр төрлийн багаж тоног төхөөрөмжөөр хангагдсан. Тус дэмжих төв нь 2022 оны 5 дугаар сарын 7-ны өдөр нээлтээ хийж, урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэгийн насанд хүрэгчдийн багцын үзлэг хийж байна. Тайлант хугацаанд Эрүүл мэндийг дэмжих төвд 4893 буюу насанд хүрэгчдийн 7.1% үзлэгт хамрагдсан байна.

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг нэг худалдан авагчийн тогтолцоонд шилжүүлж, гүйцэтгэлээр санхүүжих тогтолцоог бий болгосноор төр, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагад эрүүл мэндийн даатгалын сангаас олгох зардлын ялгаа арилсан байна.

Эрүүл мэндийн даатгалын сангаас улс, хувийн эмнэлгийг ялгахгүйгээр яаралтай тусламж, эрчимт эмчилгээ, хорт хавдар, гэмтэл, түлэгдэлт, тархины цус харвалтын зэрэг нэн шаардлагатай тусламж, үйлчилгээг бүрэн санхүүжүүлсний үр дүнд эдгээр тусламж,

үйлчилгээ үзүүлэгч эрүүл мэндийн байгууллагын тоо нэмэгдэж, тусламж, үйлчилгээний хүртээмж нэмэгдсэн байна.

Даатгуулагчийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамруулж, төлбөрийг нь Эрүүл мэндийн даатгалын сангаас хариуцан хэрэгжүүлж байна.

Орон нутагт эмнэлгийн шатлалаас хамааран зарим оношийн хамааралтай бүлгээр эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхэд хязгаарлалт үүч байна. Тухайлбал: Эрчимт эмчилгээний А эрэмбээр тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа боловч лавлагаа шатлалын эмнэлэг тул эрчимт эмчилгээний В эрэмбээр санхүүжиж, тусламж үйлчилгээ үзүүлж байна.

A1.2. Эрүүл мэндийн даатгалын үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог үр дүнтэй зохион байгуулж байна.

Эрүүл мэндийн салбарт хэрэгжиж байгаа даатгалын санхүүжилтийн шинэчлэлийн хүрээнд эрүүл мэндийн даатгалын санд Төрөөс төлбөрийг нь хариуцах тусламж, үйлчилгээний зардал нэмэгдсэн байна.

Эмнэлгүүдийг үзүүлсэн тусламж, үйлчилгээний тохиолдлоор буюу гүйцэтгэлээр нь санхүүжүүлдэг болсны үр дүнд иргэнээ дагасан санхүүжилтийн тогтолцоо бий болж, санхүүгийн эрсдэл, чирэгдэл буурах, эмнэлгийн санхүүгийн менежмент сайжрах, эмч, эмнэлгийн ажилчдын цалин нэмэгдэх боломжтой болжээ.

Гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн арга хэлбэрийг нэвтрүүлж, эмнэлгийн хагас бие даасан байдлыг ханган, нэг худалдан авагчийн тогтолцоонд шилжүүлэх замаар улсын төсөв, эрүүл мэндийн даатгалын үр ашгийг дээшлүүлж, иргэдийн эрүүл мэндээс шалтгаалсан санхүүгийн бэрхшээлийг бууруулсан байна.


Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 01 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан оношийн хамааралтай бүлгийн 705 жагсаалтаас, үйл ажиллагаа явуулж байгаа, тусгай зөвшөөрөлтэй, магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагатай тусламж, үйлчилгээ үзүүлэх чадамж, хүртээмжийг нь харгалзан сонгон шалгаруулж гэрээ байгуулан ажилласан байна.

Эмч, мэргэжилтнүүд олон улсын эмнэл зүйн удирдамжийн Up To Date цахим платформыг ашигласнаар эмчилгээ оношилгоог олон улсын жишигт нийцүүлэн, нотолгоонд суурилан хийх боломж бүрдсэн байна.

ХОЁР. ТӨРИЙН БОЛОН ХУВИЙН ХЭВШЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ОРЛОГО НЭМЭГДЭЖ, ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖ САЙЖИРСАН БАЙНА.

Б1.1. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого, хамрагдалтын төлөвлөгөөг бодит гүйцэтгэлд үндэслэж батлаагүй, биелэлтийг бүрэн хангаж ажиллаагүй байна.

Эрүүл мэндийн сангийн орлого, зарлагын төлөвлөгөөг ЭМДЕГ-ын даргаар батлуулсан байна.



Тайлбар: Орлогын гүйцэтгэлийг Орхон аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2021, 2022 оны санхүүгийн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлангийн дүнгээс авав.

Орхон аймгийн ЭМДС-н 2021 оны орлогын төлөвлөгөөг 16,555.7 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 18,111.3 сая төгрөг буюу 109.4 хувиар биелсэн байна.

Харин 2022 оны орлогыг 35,372.7 сая төгрөгөөр /ажил олгогч, даатгуулагчийн шимтгэл 34,471.8 сая төгрөгөөр, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн малчин суралцагсдын шимтгэл 901.1 сая төгрөгөөр/ баталж, гүйцэтгэлээр 21,073.4 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн буюу орлогын төлөвлөгөө 59.6 хувьтай биелсэн байна.

Энэ нь ЭМДС-ын 2022 оны орлогыг өмнөх оноос 18,816.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж үндэслэлгүй төлөвлөсөнтэй холбоотой байна.

Орхон аймгийн хэмжээнд 2021 онд төр хариуцах 76,398 иргэний 480.3 сая төгрөгийг, 2022 онд 71,172 иргэний 422.2 сая төгрөгийг даатгалын санд төвлөрүүлсэн байна.

ЭМДЕГ-ын даргын 2021 оны А/10, 2022 оны А/13 дугаар тушаалын хавсралтаар эрүүл мэндийн даатгалд хамралтын төлөвлөгөөг баталсан байна.

Хүснэгт №1 Хамрагдалтын төлөвлөгөөнд төлөвлөсөн болон хамрагдсан иргэд

Он	Малчид		Оюутан суралцагчид		Хөдөлмөр эрхлээгүй иргэд	
	Төлөвлөсөн	Хамрагдсан	Төлөвлөсөн	Хамрагдсан	Төлөвлөсөн	Хамрагдсан
2021	550	114	2,000	233	10,500	4,459
2022	700	110	2,000	202	9450	7,698
Дүн	1,250	224	4,000	435	19,950	12,157

Дээрх хүснэгтээс харахад тус төлөвлөгөөний хүрээнд хамаарах иргэдийн эрүүл мэндийн даатгалд хамрагдалт маш бага байна.

Тухайлбал оюутан суралцагчдыг жил бүр 2000 хүнээр төлөвлөж, гүйцэтгэлээр хамрагдалт 10 хувьтай гарсан байна. Гэтэл аймгийн статистикийн хэлтсийн албан ёсны мэдээллээр 2400 оюутан суралцагч бүртгэлтэй байна.

ЭМДЕГ нь орон нутгийн ЭМДХ-ийн жилийн орлогын төлөвлөгөөг батлахдаа өмнөх оны гүйцэтгэл болон хэлтсийн саналд тулгуурлалгүй баталдаг. ЭМДХ-ээс төсвийн төсөөлөл авдаггүй байна.

Иймд орлого, хамрагдалтын төлөвлөгөөг өмнөх онуудын бодит гүйцэтгэл, ирэх оны тооцоо судалгаанд үндэслэн төлөвлөх, баталсан төлөвлөгөөг бүрэн хэрэгжүүлэх бүх талын арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Б1.2. Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтийг хянаж, гүйцэтгэлийг тайлагнаж байна.

Орхон аймагт үйл ажиллагаа явуулж буй байгууллагууд ЭМДЕГ-тай байгуулсан гэрээгээр даатгуулагчдад эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, эмийн үнийн хөнгөлөлт үзүүлснээр 2021 онд нийт 47,097.1 сая төгрөгийг нэхэмжилж, цахим программын хяналтаар 3,392.1 сая, эмч, байцаагчийн хяналтаар 2,513.4 сая төгрөгийг хасаж, 41,191.6 сая төгрөгийн санхүүжилт ЭМДС-аас олгосон байна.

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, эмийн үнийн хөнгөлөлтийн хүрээнд 2022 онд нийт 45,554.4 сая төгрөг нэхэмжилж, цахим программын хяналтаар 2,304.0 сая төгрөг, эмч, байцаагчийн хяналтаар 1,802.9 сая төгрөгийг хасаж, 41,415.4 сая төгрөгийн санхүүжилт ЭМДС-аас олгожээ.

Хүснэгт: №2 ЭМДС-аас 2021, 2022 онд олгосон санхүүжилт /сая.төгрөг/

Он	Нэхэмжилсэн дүн	Цахим, программын хяналтаар хасагдсан дүн	Нэхэмжлэхийн хяналтаар хасагдсан дүн	Олгохоор тооцсон санхүүжилт
2021	47,097.1	3,392.1	2,513.4	41,191.6
2022	45,554.4	2,304.0	1,835.0	41,415.4
ДҮН	92,651.5	5,696.0	4,348.4	82,607.0

Аудитын хамрах хүрээний хугацаан дахь санхүүжилтийн дэлгэрэнгүй мэдээллийг хавсралтад харуулав.

Аудитын багаас эрсдэлд үндэслэн аймгийн ЭМДХ-ийн чанар, төлбөрийн хяналтын эмчийн хамт ЭМБ-уудын коронавируст халдварын үед хэвтэн эмчлүүлсэн даатгуулагчдын өвчний түүхийг татаж шалгахад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Орхон аймгийн хувийн хэвшлийн 6 эмнэлэг нь коронавируст халдвар /ковид-19/-ыг хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ үзүүлсэн хөнгөн хэлбэрийн нийт 54 даатгуулагчийг зэрэг ахиулан хүндэвтрээр нэхэмжилж, тус эмнэлгүүдэд эрүүл мэндийн даатгалын сангаас 63.7 сая төгрөгийн санхүүжилт илүү олгосон байна.

Энэ нь Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 13.1-д “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллага дараах эрх, үүрэгтэй”, 13.1.6-д “эрүүл мэндийн даатгалын сангаас төлүүлэх даатгуулагчийн төлбөрийн тайлан тооцоо, холбогдох баримт бичгийг үнэн зөв, цаг хугацаанд нь гаргаж эрүүл мэндийн даатгалын байгууллагад ирүүлэх”, 16.1-д “Эрүүл мэндийн даатгалын байгууллага нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ”, 16.1.5-д “даатгуулагчид үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар болон зардлын төлбөрт хяналт тавьж, энэ хуулийн 14.8.7-д заасан журамд тусгагдсан шалгуур хангасан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд төлбөр олгох”, 23.2.3-д “эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын болон төлбөрийн хяналтыг энэ хуулийн 14.8.7-д заасан журмын дагуу цахим болон бусад хэлбэрээр хэрэгжүүлэх”, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 12 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Чанар, төлбөрийн

хяналтын журам"-ын 3.7.3-д "ЭМБ нь үзүүлсэн тусламж, үйлчилгээний төлбөрийг нэхэмжлэхдээ бодит байдлаас давуулан илүү өндөр өртөгтэй тусламж, үйлчилгээний код ашиглан нэхэмжилж код ахиулах" гэж заасантай нийцэхгүй байна.

Хүснэгт №3 Коронавируст халдвараар өвчилж, эмчлүүлсэн даатгуулагчийн хүндийн зэргийг ахиулж нэхэмжилж, илүү санхүүжилт авсан ЭМБ-ын жагсаалт.

Д/д	Эмнэлгийн нэр	Хүндийн зэрэг ахиулж нэхэмжилсэн	
		Тоо	Дүн /сая.төгрөг/
1	Таван талын булаг	12	14.2
2	Баян-Өндөр мед	6	7.1
3	Ачит	3	3.5
4	Бадархундага	7	8.3
5	Тайхар	9	10.6
6	Очир-Увидас	17	20.0
ДҮН		54	63.7

Орхон аймгийн БОЭТ нь 2022 оны 01 дүгээр сард коронавируст халдвараар Очир-Увидас эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн 1 даатгуулагчийг цаг хугацааны хувьд давхардуулан эмчилснээр бүртгэж, 2.2 сая төгрөгийн санхүүжилтийг Эрүүл мэндийн даатгалын сангаас нэхэмжилж авсан байна.

Энэ нь Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 13.1-д "Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллага дараах эрх, үүрэгтэй", 13.1.6-д "эрүүл мэндийн даатгалын сангаас төлүүлэх даатгуулагчийн төлбөрийн тайлан тооцоо, холбогдох баримт бичгийг үнэн зөв, цаг хугацаанд нь гаргаж эрүүл мэндийн даатгалын байгууллагад ирүүлэх", 16.1-д "Эрүүл мэндийн даатгалын байгууллага нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ", 16.1.5-д "даатгуулагчид үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар болон зардлын төлбөрт хяналт тавьж, энэ хуулийн 14.8.7-д заасан журамд тусгагдсан шалгуур хангасан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд төлбөр олгох", 23.2.3-д "эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын болон төлбөрийн хяналтыг энэ хуулийн 14.8.7-д заасан журмын дагуу цахим болон бусад хэлбэрээр хэрэгжүүлэх", Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 01 дүгээр тогтоолын гуравдугаар хавсралтаар баталсан "Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах тусламж үйлчилгээний нэгж тохиолдлыг тооцох, тохиолдлыг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх журам"-ын 5.1-ийн тавдугаарт тодорхойлсон "Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ"-ний "Эмийн эмчилгээ" тусламж үйлчилгээний төрлийн 1-д "Эмч, эрүүл мэндийн байгууллагын буруутай үйлдэл, эсхүл өмнөх тусламж, үйлчилгээг хангалтгүй үзүүлснээс шалтгаалан даатгуулагч тухайн оношоор давтан хэвтүүлэн эмчлүүлсэн нь ЭМДЕГ-ын чанар, төлбөрийн хяналтын үйл ажиллагаагаар нотлогдсон тохиолдолд давтан хэвтэлтийг санхүүжүүлэхгүй" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд дээрх 7 эрүүл мэндийн байгууллагад нийт 65.9 сая төгрөгийг эрүүл мэндийн даатгалын санд буцаан төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоолоо.

БОЭТ-ийн гэмтлийн тасалт 2022 оны 04-р сард үений хагалгаа хийлгэсэн 6 даатгуулагчийн хамтын төлбөрийг илүү нэхэмжлэн авсан 9.7 сая төгрөгийн төлбөрийн актыг барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй, 2021 оны 11-р сард ковидын халдварыг хэвтүүлэн эмчилсэн 1 даатгуулагчийн 4.2 сая төгрөгийг Очир-Увидас эмнэлэг болон БОЭТ-д давхардуулан санхүүжилт олгосон байна.

Б1.3. ЭМДЕГ-аас эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагатай даатгалын гэрээ байгуулж, гүйцэтгэлийг дүгнэж байна.

Орхон аймагт үйл ажиллагаа явуулж буй 1 БОЭТ, 11 хувийн хэвшлийн эмнэлэг, 1 Сувилал, 9 АШЭМБ, 64 эмийн сан буюу нийт 86 эрүүл мэндийн байгууллагатай эрүүл мэндийн тусламж үйлчилгээг худалдан авах гэрээ байгуулан ажиллаж байна.

Үндсэн тусламж үйлчилгээний чиглэлээр 2022 онд “Баян-Өндөр мед” эмнэлэг болон “Эрдэнэт Медикал” ХХК эмнэлгүүд шинээр гэрээ байгуулсан байна.

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж байгаа эрүүл мэндийн байгууллагуудын гэрээг ЭМДЕГ-т гэрээг дүгнэдэг.

Орхон аймгийн 15 эмийн санд эрүүл мэндийн даатгалын тухай хууль тогтоомж, эрүүл мэндийн даатгалын гэрээний хэрэгжилтэд хяналт үнэлгээ хийхэд гэрээний хэрэгжилтийг бүрэн хангаагүй байсан тул нэмэлтээр 49 эмийн санд хяналт үнэлгээ хийж нийт 64 эмийн сан хамрагдсан байна. Хүний нөөц, анхан шатны бүртгэл хөтлөлт, байршил, даатгуулагчдад эмийн сонголт болон эм худалдан авах зориулалт бүхий дэлгэц касс дээр байршуулаагүй зэрэг зөрчлүүд илэрсэн тул Жинст, Маналжалбуу, Цэгцүүхэй, Монос эрдэнэт, Орхон, Орхон-2, Азифарм, Итгэлт-анар зэрэг 8 эмийн санд гэрээг түдгэлзүүлэх, Бадмаараг, Мөнх-алтаргана, Болор, Оюуфарм, Наран, Вансэмбэрүү, Баян-өндөр мед зэрэг 7 эмийн санд гэрээг цуцлах мэдэгдлийг худалдан авалт, гэрээлэлтийн газарт хүргүүлж, 7 эмийн сангийн гэрээг цуцалсан байна. Гэрээг түдгэлзүүлсэн 8 эмийн сангуудад хугацаатай албан шаардлага өгч биелэлтийг хангуулан гэрээг сэргээсэн байна.

Мөн Эрүүл мэндийн даатгалын хэлтэс эмийн сангуудын 2022 оны гэрээг дүгнэж 30 эмийн сангийн гэрээг түдгэлзүүлж, албан шаардлага хүргүүлж биелэлтийг хангуулан 26 эмийн сангийн гэрээг сэргээж, 4 эмийн сангийн гэрээг цуцалсан байна.

Эмийн сангуудтай байгуулсан “Даатгуулагчдад эмийн хөнгөлөлт үзүүлэх үйлчилгээг худалдан авах гэрээг”-г дүгнэж, дүнгийн нэгтгэл, саналыг хугацаанд нь хүргүүлсэн байна.

Б1.4. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж буй төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудад олгосон санхүүжилт үр нөлөөтэй байна.

Хувийн хэвшлийн эмнэлгүүд эрүүл мэндийн даатгалаар эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллага болсноор даатгуулагчаас гарах төлбөр багассан байна.

Аймгийн хэмжээнд 2021 онд 10000 хүн тутамд 37 их эмч, 41 сувилагч, 98 ор, нэг их эмчид 270 хүн, нэг сувилагчид 234 хүн ногдож байсан бол, 2022 онд 42 их эмч, 46 сувилагч, 98 ор, нэг эмчид 241 хүн, нэг сувилагчид 218 хүн ногдож байна.

График №2 Арван мянган хүн тутамд ногдох эмч, сувилагч, орны тоо.





График №3 Нэг эмч, сувилагчид ногдох хүний тоо



Эрүүл мэндийн байгууллагуудын хүний нөөцийн хангалт нэмэгдэж, үзүүлж буй тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж сайжирсныг харуулж байна.

Эрүүл мэндийн байгууллагууд гүйцэтгэлтийн санхүүжилтэд шилжсэнээр техник, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийж, ажилтнуудын цалин хөлсийг нэмэгдүүлж, нийгмийн асуудлыг шийдвэрлэж эхэлсэн байна.

Нөгөө талаар мэргэшсэн эмч, мэргэжилтнүүд анхан шатны эрүүл мэндийн төвүүдэд удаан ажилладаггүй, дээд шатны эрүүл мэндийн байгууллагад шилжин ажиллах хөдөлгөөн их болж зарим нарийн мэргэжлийн эмчийн хүрэлцээ хангалтгүй, хүний нөөц дутмаг байна.

Эрүүл мэндийн байгууллагууд 2021 онд давхардсан тоогоор 671.7 мянган хүнд үзлэг хийснээс 39.9 хувийг нь урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулжээ. Энэ нь өмнөх оноос нийт үзлэг 3.6 хувиар, урьдчилан сэргийлэх үзлэг 14.3 хувиар их байгаа бол 2022 онд давхардсан тоогоор 683.3 мянган хүнд үзлэг хийснээс 36.0 хувийг нь урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан нь өмнөх оноос нийт үзлэг 1.7 хувиар нэмэгдэж, урьдчилан сэргийлэх үзлэг 8.3 хувиар буурсан байна.

Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд давхардсан тоогоор 2021 онд 149.2 мянган хүнд үйлчилснээр, өмнөх оноос үйлчлүүлсэн хүний тоо 27.0 хувиар, орлого 81.8 хувиар нэмэгдсэн байна.

Аймгийн хэмжээнд 2021 онд 2,502 эх амаржиж, 624 хүн нас барсан, 2022 онд 2,287 эх амаржиж, 542 хүн нас барсан байна.

Халдварт өвчнөөр 2021 онд өвчилсөн 12,229 тохиолдлын 94.5 хувь нь, 2022 онд өвчилсөн 4,855 тохиолдлын 82.7 хувь нь коронавируст халдвараар өвчлөгсөд эзэлж байна.

Эрүүл мэндийн даатгалын байгууллагатай гэрээ байгуулсан эмийн сангууд цахим жороор харьяалал харгалзахгүй хөнгөлөлттэй эмээр үйлчилж байгаатай холбоотой хүртээмж, хүлээгдэл чирэгдэл багассан байна.

Хүснэгт №4 ЭМБ-д хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ авсан даатгуулагчийн тоо

Огноо	Хэвтэн эмчлүүлсэн хүний тоо	Хэвтсэн тохиолдлын тоо	Оношийн хамааралтай бүлгийн тоо	Үүнээс: 5-аас дээш удаа хэвтэн эмчлүүлсэн	
				Хүний тоо	Тохиолдлын тоо
2021	22,696	28,062	1,300	72	394
2022	23,761	30,424	1,329	118	645
Нийт	46,457	58,486	2,629	190	1,039

Дээрх хүснэгтээс харахад 2022 онд 5-аас дээш удаа хэвтэн эмчлүүлсэн 118 даатгуулагчийн 645 тохиолдол /үүнээс 13 даатгуулагчийн 70 тохиолдол нь 3-аас доош насны хүүхэд/, 2021 онд 72 даатгуулагчийн 394 тохиолдлыг бүртгэсэн байна.

Үүнээс гадна зарим тохиолдолд даатгуулагчид хувийн эрүүл мэндийн байгууллагуудад хэвтсэний дараагаар 13А маягтыг авахаар ӨЭМТ-өөс шаарддаг байна.


Эдгээр нь зайлшгүй хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ үзүүлэх шалгуур үзүүлэлтийн тодорхойлсон журам, заавар, удирдамж боловсруулаагүйтэй холбоотойгоор шаардлагагүй хэвтэн эмчлүүлэх болон тусламж, үйлчилгээний чанартай хамааралгүйгээр эмнэлэг дамжин хэвтэн эмчлүүлэх нөхцөл боломжийг бүрдүүлж байна.

Б2.1. Эрүүл мэндийн байгууллагаас эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байгаа хүн амыг тусламж үйлчилгээнд хамруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр ажил зохион байгуулаагүй байна.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод хүн амын эрүүл амьдралын хэвшлийг төлөвшүүлж, иргэн бүрийг эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээнд бүрэн хамруулж, өвчнийг эрт илрүүлэх, эмчилгээ үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, дундаж наслалтыг уртасгах зорилт дэвшүүлжээ.

Орхон аймгийн хэмжээнд сумын Эрүүл мэндийн төв, 8 Өрхийн эрүүл мэндийн төвөөр эрүүл мэндийн тусламж үйлчилгээг 2021 онд давхардсан тоогоор 179,763 иргэн, 2022 онд давхардсан тоогоор 182,595 иргэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамрагдсан байна.

График №4 Хүн амын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамрагдсан байдал



Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамрагдаагүй иргэд 2021 онд 10,882, 2022 онд 11,076 байна. Шалтгааныг дурдвал:

- Өдрийн 8 цагаар ажилладаг иргэд
- Хувиараа бизнес эрхлэгч
- Цар тахлын хөл хориотой үе
- Гадаад сурч амьдардаг иргэд
- Хөдөө уул уурхайд ажилладаг хөдөлгөөнтэй иргэд
- Хаяг тодорхойгүй байдал /давхцал/
- Төвөөс алслагдсан
- Эмнэлэгт ханддаггүй харьцангуй эрүүл иргэд
- Амьдралын түвшинтэй холбоотой
- Иргэдийн эрүүл мэндийн боловсрол муу зэргээс шалтгаалж байна.

Дээрх шалтгаанаар эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байгаа иргэдэд тусламж үйлчилгээнд хамруулах ажил зохион байгуулаагүй байна.

Харин аймгийн Эрүүл мэндийн газар, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Гэр бүлийн сайн сайхны төлөө нийгэмлэгийн Орхон аймаг дахь салбартай хамтран 21 багийн амьжиргааны баталгаажих төвшнөөс доогуур орлоготой, алслагдсан болон өсвөр үе, зорилтот бүлгийн 956 эмэгтэйд НҮЭМ-ийн тусламж үйлчилгээг явуулаар үзүүлж, урьдчилан сэргийлэх үзлэг, эрүүл мэндийн боловсрол олгох, гэр бүл төлөвлөлтийн талаар сургалт зохион байгуулсан байна.

Явуулын тусламж үйлчилгээнд Жаргалант сумын Дулаан-Уул багт 1 удаа 6 чиглэлд 165 өрхөд 355 хүнийг хамруулсан байна. Орхон аймгийн хэмжээнд 2021 онд 25 багийн 102,634 иргэн, 2022 онд 102,719 иргэн Сумын эрүүл мэндийн төв болон 8 Өрхийн эрүүл мэндийн төвөөр эрүүл мэндийн тусламж үйлчилгээг авсан байна.

Гэвч аймгийн хэмжээнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байгаа хүн амыг тодорхойлох судалгаа хийгээгүй, мэдээлэлгүй байгаа нь Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.2¹, 13 дугаар зүйлийн 13.3²-д заасантай тус тус нийцэхгүй байна.

Монгол Улсад мөрдөгдөж буй MNS 5292:2017 Өрхийн эрүүл мэндийн төвийн бүтэц, үйл ажиллагааны стандартын дагуу өрхийн эмч, сувилагч 1800-2000 хүн ам тутамд 1 байхаар заасан байдаг. Орхон аймгийн Өрхийн эрүүл мэндийн төвүүд 1 эмчид 1,741 хүн ноогдож байгаа нь стандартын дагуу хүний нөөцөө бүрдүүлэн ажиллаж байна.

¹ Эрүүл мэндийн тухай хуулийн 11.2.2-д “харьяалах нутаг дэвсгэрийн хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тэгш, хүртээмжтэй байдлыг хангах”

² Эрүүл мэндийн тухай хуулийн 13.3-д “Эрүүл мэндийн байгууллага нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг дангаараа болон бусад аж ахуйн нэгж, байгууллага, олон нийт, иргэдтэй хамтран явуулна”

Хүснэгт №5 Орхон аймгийн ӨЭМТ-ийн 1 эмчид ногдох иргэдийн тоо

№	ЭМТ-ийн нэр	Харьяалагдах багийн иргэдийн тоо	Эмчийн тоо		1 эмчид ногдох хүний тоо
			Стандарт	Одоо ажиллаж байгаа	
1	Анхны оч	21,526	12	11	1,956
2	Мэнд цэцэн	18,125	9	8	2,265
3	Мөнхийн гэгээ	7,780	4	4	1,945
4	Мөнх сүндрэл	8,953	7	7	1,279
5	Үйлс бадрах	10,912	9	8	1,364
6	Учралт баяр	13,156	8	7	1,879
7	Энхжих мандирваа	10,154	5	5	2,030
8	Нийцэл	12,754	8	8	1,594
9	Жаргалант сумын ЭМТ	3,417	3	3	1,139
Дүн		106,231	65	61	15,451

Б2.2. Эрүүл мэндийн даатгалын үйлчилгээнд даатгуулагч, эмнэлэг, эмийн сан, даатгалын байгууллага болон бусад төрийн байгууллагыг холбосон найдвартай цахим мэдээллийн системийг үе шаттай хөгжүүлж байна.

Орхон аймгийн БОЭТ нь E-health, хувийн хэвшлийн эмнэлгүүд эмнэлгийн мэдээллийн цогц систем болох Аксис систем ашиглаж, мэдээлэл боловсруулж эрүүл мэндийн даатгалын health.gov.mn системд мэдээлэл дамжуулж байна.

Эмийн сангууд өөрсдийн нөөц бололцоондоо тохируулан олон төрлийн программ ашигладаг ба Монгол Эм Импекс Концерн Орхон аймаг дахь салбар, Монос фарм Орхон аймаг дахь салбар IRP, Ази фарм 1С, бусад эмийн сангууд ORION pharma, Инфо систем, ODOO зэрэг программыг ашиглаж эрүүл мэндийн даатгалын хэлтэст сар бүр хөнгөлөлттэй эмийн тайланг health.gov.mn программд илгээдэг байна.

Өрхийн эрүүл мэндийн төвүүд <https://ehospital.gov.mn/> программыг ашиглан хөнгөлөлттэй эм болон, ЭМД-ийн 4 багцын /өдрийн эмчилгээ, сэргээн засах тусламж үйлчилгээ, гэрээр үзүүлэх тусламж үйлчилгээ, оношилгоо шинжилгээ/ тусламж үйлчилгээг бүртгэдэг ба дараах хүндрэлүүд гардаг байна. Үүнд:


1. Хөнгөлөлттэй эм бичих үед 15 минутын зайтай бичдэг, тухайн иргэний хурууны хээг танихгүй, уншихгүй байх.
2. 7 хоногийн эхний өдөр гацаж иргэдийн бухимдлыг хүргэж, эмч үйлчлүүлэгчийн хооронд үл ойлголцол бий болгодог.
3. Үе үе сервер дээр хөгжүүлэлт хийж байна гэж гацдаг.
4. Эрүүл мэндийн даатгалын 4 багцын тусламж үйлчилгээг иргэдэд үзүүлж ЭМД илгээсний дараа шалгалтаар ямар алдаа гарсны улмаас хасагдсан гэдгээ харах боломжгүй.
5. Зарим асаргаа болон хэвтрийн хүмүүсийг хурууны хээгүй үйлчлүүлдэг болгохын тулд баримт бүрдүүлэн албан бичиг бичиж илгээсний дараа маш их удаж шийдэгддэг.
6. 08:00-17:00 цагийн хооронд программ ажиллаж бусад үед ажлын цаг дууссан гээд бичиж болдоггүй зарим ажилтай иргэд хөнгөлөлттэй эмээ бичүүлж чадахгүй буцдаг.

Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн <https://ehospital.gov.mn/> программ нэг үйлдэл хийхэд олон шат дамжлагатай, баазын хүчин чадал бага, сар бүр Эрүүл мэндийн даатгалын хэлтэст явуулдаг тайлан дутуу татагддаг зэргээс үүдэн цаасаар давхар явуулдаг зэрэг нь

өрхийн эрүүл мэндийн төвүүдэд цахим мэдээллийн системийн хөгжил, иргэдийг найдвартай мэдээллээр хангах, чанартай тусламж үйлчилгээ үзүүлэх нөхцөл дутмаг байна.

Иргэд эрүүл мэндийн даатгал, тусламж үйлчилгээний талаар хангалттай мэдээлэлгүй болохыг судалгааны дүн харуулж байна.

График №5 Иргэдээс авсан санал асуулгын дүн.



Эрүүл мэндийн даатгалын үйлчилгээнд даатгуулагч, эмнэлэг, эмийн сан, даатгалын байгууллага болон бусад төрийн байгууллагыг холбосон найдвартай цахим мэдээллийн системийг хөгжүүлэн ажиллаж байгаа гэх боловч программ хангамжийн хөгжүүлэлт хангалттай гэж үзэхээргүй байна.

Эрүүл мэндийн сайдаас Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газарт өгсөн чиглэлийн дагуу сумдын болон өрхийн эрүүл мэндийн төвд ашиглаж байсан e-hospital цахим системийг шаардлага хангахгүй гэх шалтгаанаар зогсоож e-health цахим системийг 2023 оны 05 дугаар сарын 05-ны өдрөөс нэвтрүүлж, системийн хөгжүүлэлт сургалт мэдээллийн ажлыг хийжээ.

Б2.3. Эрүүл мэндийн даатгалын байгууллага нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээний талаар даатгуулагчдад шаардлагатай мэдээллийг цахим мэдээллийн хэрэгслээр хүргэж байгаа хэдий ч хүртээмж хангалтгүй байна.

Эрүүл мэндийн даатгалтай холбоотой мэдээ, мэдээллийг зурагт постер, хөдөлгөөнт постер, лайв, видео хэлбэрээр хэлтсийн албан хаагчид өөрсдийн фэйсбүүк болон хэлтсийн цахим хуудаст байршуулж байна.


Эрүүл мэндийн даатгалын сангийн үйл ажиллагаатай холбоотой бүхий л мэдээллийг цогцоор авч болох Edaatgal гар утасны апплкейшинг 2021 онд 1166 хүн, 2022 онд 1453 хүн ашиглаж байгаа нь Орхон аймгийн насанд хүрсэн хүн амын 2.1%-ийг эзэлж байна.

Эрүүл мэндийн даатгалын хэлтэст иргэдээс 2021-2022 онд нийт 35 өргөдөл ирснийг Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.12³, 23 дугаар зүйлийн 23.2.2⁴ дахь заалт, холбогдох журмын дагуу шийдвэрлэн, хариуг хүргүүлсэн байна.

³ Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 16.1.24-д “даатгуулагчид үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжтэй холбоотой санал, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх”

⁴ Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 23.2.5-д “эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар болон төлбөрийн талаар даатгуулагчийн гаргасан өргөдөл, гомдол, саналыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэж, даатгуулагчийн эрхийг хамгаалах”

График №6 Өргөдөл гомдлын шийдвэрлэлт



Хувийн хэвшлийн эмнэлэгтэй холбоотой 15 өргөдөл, гомдлоос Очир-Увидас эмнэлэгтэй холбоотой 12 иргэнээс ирүүлсэн 2.5 сая төгрөгийн гомдлын дагуу 2022 оны 04-06 дугаар сарын өвчтөний түүхүүдэд 07 дугаар сард дахин чанарын төлбөрийн нэмэлт хяналтыг хэрэгжүүлэн нийт 518 хүний 267.4 сая төгрөгийн нэхэмжлэлийг хянаж 146 хүний 74.5 сая төгрөгийн зөрчил илрүүлэн холбогдох арга хэмжээг авсан байна.

Таван талын булаг, ИХ тавт зэрэг хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудад (ӨЭМТ-өөс 13А маягт аваагүй төр хариуцах) 3 иргэнээс эмчилгээний төлбөр авсан өргөдөл гомдлыг шийдвэрлэн 378.0 мянган төгрөгийн төлбөрийг иргэдэд буцаан олгосон байна.

Эрүүл мэндийн газарт 2021, 2022 онд ирсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээтэй холбоотой өргөдөл, гомдлын дийлэнх хувийг


- Тусламж, үйлчилгээний хүлээгдэл, чирэгдлийг бууруулах
- Эмчийн харьцаа хандлага
- Нэмэлт төлбөр авсан асуудлууд эзэлж байна.

Аудитаар 25-60 насны иргэдээс эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжтэй холбоотой сэтгэл ханамжийн талаар судалгаа авахад оролцогчдын 90 хувь нь эрүүл мэндийн даатгалын байгууллага нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээний талаар даатгуулагчийг шаардлагатай мэдээ мэдээллээр хангахгүй байна гэж хариулсан байна.

БОЭТ-ийн захирлын 2022 оны А/109 тоот тушаалаар цаг товлох үйлчилгээний журмыг шинэчлэн баталж цаг товлох үйлчилгээний ажилтны тоог 5 болгож нэмэгдүүлсэн байна. 2021, 2022 онд томуу, томуу төст өвчин эрс нэмэгдэж Хүүхдийн тасгийн хүлээн авахаар ирэх хүүхдийн тоо нэмэгдсэнтэй холбоотой, хүүхдийн тасагт эмч, сувилагч нэмж ажиллуулснаар ачааллыг тэнцвэржүүлэн иргэдийн хүлээгдлийг бууруулсан байна.

25-60 насны 100 иргэнээс эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжтэй холбоотой сэтгэл ханамжийн судалгааг авч нэгтгэн үр дүнг доорх графикаар харуулав.

График№5 Иргэдийн санал асуулга



Дээрх судалгааны үр дүнгээс харахад эрүүл мэндийн даатгалын байгууллага нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээний талаар даатгуулагчийг шаардлагатай мэдээллээр хангах ажил маш хангалтгүй байна.


Б3.1. Бодлогын баримт бичигт тусгасан зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд хууль хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг тооцсон байна.

Эрүүл мэндийн даатгалын хэлтэс нь тухайн жилийн үйл ажиллагааны тайлан болон Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг хагас бүтэн жилээр гаргаж ЭМДЕГ-т хүргүүлж дүгнүүлдэг байна. Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай байгуулсан 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд дараах 5 зорилтыг дэвшүүлж ажилласан байна.

1. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогыг бүрдүүлэх, даатгалын хамралтыг нэмэгдүүлнэ.
2. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын болон санхүүгийн шалгуур үзүүлэлтийн дагуу хяналтыг хэрэгжүүлнэ.
3. Иргэд, даатгуулагчдад салбарын хууль, тогтоомжийг сурталчлан таниулах, хуулийн хэрэгжилтийг мэдээлэх, бусад байгууллагуудтай хамтран ажиллах, даатгалын сургалт, сурталчилгааг хийнэ.
4. Эрүүл мэндийн байгууллагуудтай гэрээ байгуулж, гэрээг дүгнэж, үр дүнг тооцож тайлагнана.
5. Хэлтсийн дотоод ажил, архив, албан хэрэг хөтлөлтийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу хөтлөх, хэрэгжилтийн явц, үр дүнг тайлагнана.

Дээрх 5 зорилтын хүрээнд 23 арга хэмжээг авч хэрэгжүүлж, гүйцэтгэлийн төлөвлөгөөг 97.6%-тай дүгнүүлсэн байна.

График №8 Хэлтсийн албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт



ЭМДХ-ийн 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт болон үйл ажиллагааны бичмэл тайланг ЭМДЕГ-т явуулж дүгнүүлсэн гэх боловч үнэлэгдэж дүгнэгдсэн нотлох баримт аудитын хугацаанд ирүүлээгүй. Бичмэл тайланг цахимаар ирүүлсэн.

Аймгийн Засаг даргатай байгуулсан 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд дараах зорилт, арга хэмжээг тусгасан байна.

1. Эрүүл мэндийн даатгалын талаарх бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн удирдлагаар хангана.
2. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогыг бүрдүүлэх, даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлнэ.
3. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын болон санхүүгийн шалгуур үзүүлэлтийн дагуу хяналтыг хэрэгжүүлнэ.
4. Иргэд, даатгуулагчдад салбарын хууль, тогтоомжийг сурталчлан таниулах, хуулийн хэрэгжилтийг мэдээлэх, бусад байгууллагуудтай хамтран ажиллах, даатгалын сургалт, сурталчилгааг хийнэ.
5. Эрүүл мэндийн байгууллагуудтай гэрээ байгуулж, гэрээг дүгнэж, үр дүнг тооцож тайлагнана.
6. Хэлтсийн дотоод ажил, архив, албан хэрэг хөтлөлтийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу хөтлөх, хэрэгжилтийн явц, үр дүнг тайлагнана.

Эдгээр 6 зорилтын хүрээнд 27 арга хэмжээг авч хэрэгжүүлж, гүйцэтгэлийн төлөвлөгөөг 95.3%-тай дүгнүүлсэн байна.

Орхон аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт эрүүл мэндийн даатгалын сангийн үйл ажиллагаатай холбоотой зорилт, арга хэмжээ тусгаагүй байна.

Аймгийн ЭМДХ нь ЭМДЕГ-ын даргатай болон аймгийн Засаг даргатай нэг ижил гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулж, биелэлтийг тайлагнасан байна.

Б3.2. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар болон төлбөрийн хяналтыг дэлгэрэнгүй тайланг эрүүл мэндийн байгууллагад илгээх, эргэх холбоо тогтоох, иргэн даатгуулагчийг холбогдох мэдээллээр хангах асуудал дутмаг байна.

Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн шинэчлэлийн хүрээнд эрүүл мэндийн байгууллага (ЭМБ)-аас худалдан авах тусламж үйлчилгээний чанар, төлбөрийн хяналтыг нотолгоонд тулгуурлаж, цахим болон бусад хэлбэрээр хэрэгжүүлэх, чанарын шаардлага хангасан тохиолдлын төлбөрийг олгох хууль эрхзүйн орчин бүрдсэн.

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас тусламж, үйлчилгээний чанарыг хангуулах, сайжруулах чиглэлээр сонгон шалгаруулалт зохион байгуулж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ худалдан авах гэрээ байгуулах, нэхэмжлэлийн хяналт, эмнэл зүйн аудит, эрүүл мэндийн байгууллагад газар дээрх хяналт, шалгалт хийх, мессеж судалгаа явуулах зэрэг цогц арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

Эдгээр үйл ажиллагаа нь иргэн, даатгуулагчид үзүүлж буй тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах, эрүүл мэндээс үүдэлтэй санхүүгийн эрсдэлээс хамгаалах, нотолгоотой, үр дүнтэй тусламжийг худалдаж авах, ЭМБ-ын хууль бус үйл ажиллагааг илрүүлэхэд чиглэгдэж байгаа юм. Цаашилбал чанар, төлбөрийн хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлснээр эрүүл мэндийн салбарын үр дүн, үр ашиг дээшилж, тогтолцооны санхүүгийн тогтвортой үйл ажиллагаа хангагдах юм.

Эрүүл мэндийн даатгалын хэлтэс нь гэрээт байгууллагуудаас ирүүлсэн нэхэмжлэлийг Эрүүл мэндийн ерөнхий газрын даргын А/139 дүгээр тушаалаар батлагдсан журмын хүрээнд ерөнхий болон эмнэл зүйн нарийвчилсан шалгуураар, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг эмнэл зүйн ОУ-ын Up to Date программын стандарт, удирдамжийн дагуу хянаж байна.

Орхон аймгийн хэмжээнд 2022 онд БОЭТ, 8 Өрхийн эрүүл мэндийн төв, Жаргалант сумын Эрүүл мэндийн төв, 64 эмийн сан, 11 хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага, эрдэнэт сувилал зэрэг нийт 86 байгууллагын 1,920 нэхэмжлэлийн хяналт хийж 475,030 даатгуулагчийн 41,415.4 сая төгрөгийн гүйцэтгэлийн санхүүжилтийг хянаж олгосон байна. Нэхэмжлэлийн хяналт хэрэгжүүлэхэд:

1. БОЭТ-ийн нийт 21,067.4 сая төгрөгийн нэхэмжлэл ирүүлснээс 2,515.2 сая төгрөгийг хасаж 18,552.2 сая төгрөг
2. Хувийн хэвшлийн нийт 10 ЭМБ-ын 8,531.2 сая төгрөгийн нэхэмжлэл ирүүлснээс 907.2 сая төгрөгийг хасаж 7,624.0 сая төгрөг
3. 9 өрх, сумын эрүүл мэндийн төвүүдийн 5,570.2 сая төгрөгийн нэхэмжлэл ирүүлснээс 49.1 сая төгрөг хасаж 5,521.1 сая төгрөг
4. 64 эмийн сангийн 3,402.1 сая төгрөгийн нэхэмжлэл ирүүлснээс 10.4 сая төгрөг хасаж 3,391.6 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн үйл ажиллагааны тайланд нэхэмжлэлийн хяналт хийж, хяналтын хугацаанд гарсан зөрчлийг гарган сар бүр ЭМБ-уудад албан тоотоор хүргүүлэн ажилласан, илрэх зөрчил өмнөх оны мөн үетэй харьцуулахад зөрчлийн сан 90%-иар буурсан гэж тайлагнасан боловч бодит байдал дээр 2021, 2022 онуудад ЭМБ-ыг нэхэмжлэлийн хяналттай холбоотой мэдээллээр хангах, эргэх холбоо тогтоох асуудал дутмаг байна.

Тухайлбал: Бүсийн оношилгоо эмчилгээний төв нь 2023 оны 1 сараас Эрүүл мэндийн даатгалын хэлтсээс нэхэмжлэлийн хасагдлын шалтгаан, зөрчлүүдийг авч дүн шинжилгээ хийж ажиллаж байна. Харин хувийн хэвшлийн эмнэлгүүд болон ӨЭМТ-дэд нэхэмжлэлийн хасагдлын шалтгаан, зөрчлийн мэдээллийг хүргүүлээгүй байна.

Энэ нь Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 12 дугаар тогтоолоор хавсралтаар баталсан “Чанар, төлбөрийн хяналтын журам”-ын 4.1.2.3-т “Чанар төлбөрийн хяналт хийсэн нэхэмжлэлийн хяналтын тайланг гаргах, дүн шинжилгээ хийх, нэхэмжлэлийн хяналтаар хасагдсан тохиолдол тус бүрээр журмын гуравдугаар хавсралтаар батлагдсан “Нэхэмжлэлийн хяналтаар хасагдсан тохиолдлын мэдээллийг эрүүл мэндийн байгууллагад хүргүүлэх хуудасны загвар”-ын дагуу дэлгэрэнгүй тайланг гаргаж сар бүр илгээх, эргэх холбоо тогтоох, иргэн, даатгуулагчийг холбогдох мэдээллээр хангах” гэж заасантай нийцэхгүй байна.

Мөн Орхон аймгийн Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн 2022 онд хийж гүйцэтгэсэн ажлын тайлан, архивын баримт бичгийн бүрдэл хангалтгүй байна.

Өмнөх хэлтсийн дарга нь ажлаас чөлөөлөгдөхдөө албан ёсоор ажлаа хүлээлгэж өгөөгүй, ашиглаж байсан компьютерын файлыг устгасантай холбоотойгоор 2021 оны 6-10-

р сард үзүүлсэн ковидын халдварыг хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээ үзүүлсэн эрүүл мэндийн байгууллагуудын нэхэмжлэлээс 1,979.6 сая төгрөгийн санхүүжилтийг хасаж олгосон боловч хэдэн хүний, хэдэн өвчний түүхтэй холбоотойгоор хасалт хийсэн нь тодорхойгүй, холбогдох нотлох баримт байхгүй байна.

Баримтыг архивын ажлын үндсэн зааврын дагуу үдэж, архивын нэгж үүсгээгүй, цахим баримт бичиг нь албан ёсны хүчинтэй байх, үнэн зөв байх, бүрэн бүрдэлтэй байх, ашиглах боломжтой баталгаажсан байх шаардлагыг хангаагүй байгаа нь Архив албан хэрэг, хөтлөлтийн тухай хуулийн 35.2-т “байгууллагын зохион байгуулалтын нэгж (газар, хэлтэс)”-ийн дарга албан хэрэг хөтлөлтийн талаарх хууль тогтоомж, журам, стандартыг өөрийн хариуцсан нэгжийн хэмжээнд хэрэгжүүлэх ажлыг хариуцан зохион байгуулж, цаасан болон цахим баримт бичгийн албан ёсны хүчинтэй байх, үнэн зөв байх, бүрэн бүрдэлтэй, ашиглах боломжтой байхад хяналт тавина” гэж заасантай, мөн гүйцэтгэлийн төлөвлөгөөний 6 дугаар зорилтын 1.6.3-т “хэлтсийн дотоод ажил, архив, албан хэрэг хөтлөлтийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу хөтлөх, хэрэгжилтийн явц, үр дүнг тайлагнана” гэж заасантай нийцэхгүй байна.

ЭМДҮЗ-ийн 2022 оны 12 дугаар тогтоолыг хэрэгжүүлэхэд дараах шалтгаануудаар нэхэмжлэлийн хяналтын хасагдал гарч байна.Үүнд:

1. Түүвэрлэлтэд орсон баримт ЭМДҮЗ-ийн 12 дугаар тогтоолын шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангаагүй.
2. Яаралтай тусламж, түргэн тусламжийг эрэмбэ ахиулж буруу дүнгээр нэхэмжлэл илгээдэг.
3. Өвчний түүхийн бүрдэл дутуу, маягт дутуу хөтөлдөг, үүнээс шалтгаалан эмчилгээний чанар хүртээмж хангалтгүй гэж дүгнэгддэг.
4. Стандарт, удирдамжаа баримталдаггүй.
5. Тасгийн эрхлэгч эмчийн дүгнэлт бичигддэггүй, үечилсэн дүгнэлт эрчимт эмчилгээний тасагт олон хоног хэвтсэн эмчлүүлэгчид бичигддэггүй.
6. Хийгдсэн шинжилгээ, эмчлүүлж буй оноштойгоо тохирдоггүй.
7. Хоол эмчилгээний заалтыг эмчийн үзлэгт тэмдэглэдэггүй.
8. Эмнэлгээс гарах үеийн эпикризыг дэлгэрэнгүй тодорхой бичдэггүй.
9. Эрчимт эмчилгээний тасагт хэвтсэн эмчлүүлэгч яаралтай тусламжийн хуудасгүй хэвтдэг.
10. Олон улсад ашиглагдаж байгаа эмнэл зүйн удирдамжийг өөрийн онцлогт тохируулан нутагшуулаагүй.
11. Түлхүүр шалгуур хангаагүй шалтгаанаар 1 хүнд үзүүлсэн тусламж үйлчилгээг тэр чигт нь хасдаг.
12. ЭМДҮЗ-ийн 12 дугаар тогтоолд тусгагдсан оношийн хамааралтай бүлгийн эмнэл зүйн шалгуур үзүүлэлтийг өвчин тус бүрээр гаргаагүй.
13. Уламжлалт эмчилгээний оношийн хамааралтай бүлгийн тусламж үйлчилгээг, өрнийн эмчилгээтэй хослуулан эмчилснээр шалгуур үзүүлэлтэд байхгүй шалтгаанаар хасагддаг.

Даатгуулагчид тусламж үйлчилгээ үзүүлэхэд гарсан бодит зардлыг тооцохгүй, эх олонлогоор хасалт хийх нь ЭМБ-д санхүүгийн эрсдэлийг бий болгож байна.

Гэрээний биелэлтийн явцын хяналтыг хийх зорилгоор хэлтсийн даргын удирдамж батлан, лавлагаа шатлалын ХХЭМБ-уудад хяналт шалгалт хийж илэрч байгаа зөрчлийг арилгуулах зөвлөмж өгч ажилласан гэж байгаа ч нотлох баримт аудитын хугацаанд ирүүлээгүй болно.

ЭМДХ-ээс 2023 оны 2 дугаар сард БОЭТ-ийн 2022 оны 09-12 сард иргэн, даатгуулагчид үзүүлсэн 22 багц тусламж үйлчилгээний гүйцэтгэлийн 56939 тохиолдлыг хүлээн авч үүнээс түүвэрлэлтэд 2458 тохиолдлыг хамруулан нэхэмжлэлийн нарийвчилсан хяналтыг хийж гүйцэтгэхэд зарим багцын тусламж, ЭМДҮЗ-ийн 2022 оны 12 дугаар тогтоол болон ЭМДЕГ-ын даргын А/139-р тушаалаар батлагдсан нэхэмжлэлийн хяналтын дэлгэрэнгүй шалгуурын шаардлагыг хангаагүй 6 зөрчил илэрсэн тул иргэн даатгуулагчид

үзүүлэх эмнэлгийн тусламжийн чанарыг сайжруулах зорилгоор дараах 4 зөвлөмжийг БОЭТ-д хүргүүлсэн байна.Үүнд:

- Өдрийн эмчилгээний ерөнхий шалгуурын амбулаторийн кабинетын эмчээс илгээсэн бичгээр хэвтүүлж байх, өдрийн эмчилгээ хийх өвчин эмгэг нь эмчийн 24 цагийн хяналтад байх шаардлагагүй, амь насанд аюул учруулахгүй талаарх дүгнэлтийг бичиж байх, эмчлэгч эмч үзлэг хийсэн тухай тэмдэглэлийг өдөр бүр хөтөлж, үйлчлүүлэгчид дэлгэрэнгүй зөвлөгөө өгч өрх сум тосгоны болон мэргэжлийн эмчийн хяналтад гаргасан тухай дэлгэрэнгүй тэмдэглэл бичиж хэвших

- Үйлчлүүлэгчид өндөр өртөгтэй оношилгоо, шинжилгээ хийх заалтыг бүрэн гаргаж, тэмдэглэсэн байх, мөн оношилгоо хийсэн он сар өдөр, цаг минут, оношилгоонд ашигласан тодосгогч бодисын талаар бүрэн тэмдэглэх, дүрслэл оношилгооны дүгнэлтэд оношилгоогоор илэрсэн өөрчлөлтийн талаар бүрэн тусгасан байх, дурангийн ажилбарын үед авсан эдийн талаар болон шинжилгээг аль лаборатори илгээсэн тухай тэмдэглэлийг дэлгэрэнгүй, бүрэн тэмдэглэсэн байх

- Ойрын дуудлага түргэн тусламжийн дуудлагын дүгнэлтийг бичиж, өгсөн зөвлөмжийн тэмдэглэл хөтлөх, эмчилгээний тэмдэглэл, дуудлага хүлээн авсан огноо, цаг минутыг тэмдэглэж, дуудлага хүлээн авсан эмнэлгийн мэргэжилтний нэрийг бичиж байх

- Хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээний баримтад зовуурь, бодит үзлэг, оношилгоо, шинжилгээ, эмчилгээний талаар тэмдэглэлийг цаг хугацаанд нь үнэн зөв, бүрэн дэлгэрэнгүй тэмдэглэсэн байх, эмийн эмчилгээний зардлын тооцооллыг эмчилгээний хуудсанд тэмдэглэх, шаардлагатай шинжилгээ, эмчилгээг бүрэн хийж байх

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар болон төлбөрийн нэхэмжлэлд холбогдох стандарт, журмын дагуу хяналтыг тавьж ажиллаж байна.

Эрүүл мэндийн байгууллагуудаас нэхэмжлэлийн шалгуур үзүүлэлтүүд бодит байдалтай нийцэхгүй, 90-ээс доош хувиар үнэлэгдсэн тохиолдлын санхүүжилтийг тусламж, үйлчилгээний чанар, гарсан зардлыг харгалзахгүйгээр бүрэн хасдаг, эмчийн бодит үзлэг, дүгнэлтээс илүү удирдамжийн дагуу бичиж тэмдэглэх шаардлага тулгарч байгаа нь ажлын ачааллыг зохиомлоор үүсгэдэг, Уламжлалт эмчилгээний оношийн хамааралтай бүлгийн тусламж үйлчилгээг, өрнийн эмчилгээтэй хослуулан үзүүлэх шалгуур тодорхойгүй зэрэг санал хүсэлтүүдийг илэрхийлж байна.

Б3.3. ЭМДЕГ-аас болон ЭМДХ нь хяналт, шалгалтыг журмын дагуу хэрэгжүүлж байна.

Орхон аймагт 2021 онд нийт 5 хяналт шинжилгээ, үнэлгээ хийгдсэнээс 2021 оны 05 дугаар сард ЭМДЕГ-ын тусламж үйлчилгээний чанар, төлбөрийн хяналтын газрын дарга Б.Оюунцэцэгээр ахлуулсан ажлын хэсэг орон нутаг дахь Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн үйл ажиллагаатай танилцах, зөвлөн туслах чиглэлээр, мөн Эрүүл мэндийн бодлогын зөвлөх Л.Төмөрбаатар, ЭМДЕГ-ын бодлого төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн Б.Баярболд, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн хүний нөөцийн хөгжлийн албаны ахлах мэргэжилтэн Д.Дондогмаа нарын хамтарсан ажлын хэсэг эрүүл мэндийн салбарын болон даатгалын тогтолцооны өөрчлөлт, шинэчлэлт, ЭМДҮЗ-ийн баталсан 03, 05 дугаар тогтоол, Олон улсын эмнэл зүйн платформ Up Do Date программыг оношилгоо, шинжилгээ, эмчилгээнд хэрхэн ашиглах талаар арга зүйн зөвлөгөө өгч, ЭМД-ын хэлтсийн үйл ажиллагаатай танилцан зөвлөн туслах, дэмжлэгт хяналт хийж ажилласан байна.

ЭМДЕГ-ын даргын 2021 оны А/132 дугаар тушаалаар баталсан 04 дүгээр удирдамжийн дагуу Дотоод аудит, хяналт шинжилгээ, үнэлгээний газрын дарга Х.Ганцэцэгээр ахлуулсан ажлын хэсэг 2021 оны 09 сарын 09-18-ны хооронд Орон нутгийн эрүүл мэндийн даатгалын хэлтсийн дотоод зохион байгуулалт, үйл ажиллагаанд хяналт үнэлгээ хийж, Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн орлогыг цуглуулж төвлөрүүлэх, бүрдүүлэлт, хуваарилалтын үйл ажиллагааны чиглэлд санхүүгийн орлогын болон бусад холбогдох анхан шатны баримт материалд тулгуурлан хяналт үнэлгээ хийж, аймгийн ЭМБ-

ын 2021 онд байгуулсан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, худалдан авах гэрээ, даатгуулагчдад эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх, худалдан авах гэрээний хэрэгжилт, гүйцэтгэлийн санхүүжилтэд хяналт үнэлгээ хийж, эрүүл мэндийн даатгалын хуулийн шинэчлэл, ЭМДҮЗ-ийн 03 дугаар тогтоол холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах хүрээнд тухайн аймгийн ЭМБ-дад цахим сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, арга зүйн зөвлөгөө өгч ажилласан байна.

ЭМДЕГ-тай гэрээ бүхий Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн гэрээний хэрэгжилтэд хяналт үнэлгээ хийх, ПГУ Cov-SARS 2 шинжилгээ хийж буй зарим төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагуудад газар дээрх хяналт, үнэлгээ хийх удирдамжуудын дагуу 2 хяналтыг Орхон аймгийн Эрүүл мэндийн даатгалын хэлтэс хийж тайланг нэгтгүүлсэн байна.

ЭМДЕГ-ын Дотоод аудит, хяналт шинжилгээ, үнэлгээний газар нь Орхон аймагт 2022 оны 03 дугаар сард 2021 оны короновируст халдварт өвчний үед үзүүлсэн тусламж үйлчилгээний чанар болон төлбөрийн нэхэмжлэлд, 2022 оны 08 дугаар сард 2022 оны тусламж үйлчилгээний чанар болон төлбөрийн нэхэмжлэлд, 2022 оны 12 дугаар сард БОЭТ-ийн ЭМДЕГ-тай байгуулсан гэрээний үүргийн хэрэгжилтэд тус бүр 3 удаа ирж хяналт хийсэн байна.

ЭМДЕГ-ын даргын баталсан 2022 оны 01 дүгээр удирдамжийн дагуу Орхон аймагт 2022 оны 03 сарын 9-12-ны хооронд 2021 онд Коронавируст халдварын үед эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлсэн төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага, гэрээр тусламж үйлчилгээ үзүүлсэн Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд Эрүүл мэндийн даатгалын сангаас олгосон санхүүжилтэд хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн байна.

Орхон аймаг 2021 оны 6-10 дугаар сар хүртэл короновируст халдвар/ковид-19/-ын үед хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээг БОЭТ, Ачит нар, Бадархундага, Талын булаг, Тайхар, Очир-Увидас зэрэг төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд үзүүлсэн байна. Үүнээс хяналт шинжилгээ үнэлгээгээр Ачит нар, Бадархундага эмнэлгийн 2021 оны короновируст халдварын үед хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээ үзүүлсэн 6-10 дугаар саруудын өвчний түүхийг түүвэрлэн шалгаснаас Бадархундага-Рашаан ХХК-ийн Бадархундага эмнэлгийн давхардуулан нэхэмжилж авсан 10 даатгуулагчийн 7.4 сая төгрөгийн, Эрдэнэт-Ачит нар ХХК-ийн Ачит эмнэлгийн давхардуулан нэхэмжилсэн 11 даатгуулагчийн 13.7 сая, 11 даатгуулагчийн эмчилгээний зэргийг бууруулсан 13.0 сая нийт 34.1 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож барагдуулсан байна.

Мөн гэрээр үзүүлэх тусламж үйлчилгээ үзүүлсэн 8 Өрхийн эрүүл мэндийн төвүүдийг шалгахад 5 ӨЭМТ гэрээр үзүүлсэн тусламж үйлчилгээг давхардуулан нэхэмжилсэн байна.

Хяналт шалгалтын тайланд тусгасан төлбөрийн актын дүн 38.2 сая төгрөг, Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд өгсөн баримтын дүн 35.9 сая төгрөг буюу 2.3 сая төгрөгийн зөрүүтэй байна.

Хүснэгт №6 ЭМДЕГ-аас ӨЭМТ-д хүргүүлсэн төлбөрийн актын дүн. /сая.төгрөг/

№	ӨЭМТ-ийн нэрс	Даатгуулагчийн тоо /тайланд/	Даатгуулагчийн тоо /баримтаар/	Төлбөрийн актын дүн /тайланд	Төлбөрийн актын дүн /баримтаар/	Зөрүү
1	Анхны-оч	134	124	21.4	19.8	-1.6
2	Мөнхийн гэгээ	7	7	1.1	1.1	0.0
3	Нийцэл	28	28	4.5	3.8	-0.7
4	Учралт баяр	36	36	5.8	5.8	0.0
5	Энхжих мандирваа	34	34	5.4	5.4	0.0
	Дүн	239	229	38.2	35.9	- 2.3

ӨЭМТ-д актаар тогтоосон нийт 35.9 сая төгрөгийг төлж барагдуулсан байна.

ЭМДЕГ-ын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Орхон аймаг дахь гэрээ бүхий Эрүүл мэндийн байгууллагуудын 2022 оны 01-06 дугаар саруудад ирүүлсэн нэхэмжлэлд чанар, төлбөрийн хяналт хийсэн байдалд үнэлгээ хийх, нэхэмжлэлийн хяналт хийх үйл ажиллагаа нь холбогдох хууль тогтоомж, эрх зүйн баримт

бичигт нийцэж байгаа эсэхийг шалган нягтлах, ЭМДЕГ-тай байгуулсан “Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагаас эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авах гэрээ”, тус аймгийн гэрээт эмийн сангуудын хөнгөлөлттэй эм олголтын байдал, хөнгөлөлттэй эмийн жор бичиж байгаа эмч нарын үйл ажиллагаанд хяналт хийж, үнэлгээ дүгнэлт өгөх, даатгуулагчдад эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх үйлчилгээг худалдан авах гэрээний үүргийн хэрэгжилтэд хяналт хийх зорилго бүхий төлөвлөгөөт хяналт шалгалтыг 2022 оны 08 сарын 17-27-ны өдрүүдэд хийсэн байна.

Орхон аймгийн БОЭТ болон хувийн хэвшлийн эмнэлгүүдийн 2022 оны 01-06 дугаар сарын гэрээнд заасан тусламж үйлчилгээний гүйцэтгэлийг хянах зорилгоор холбогдох өвчний түүхийг татаж хяналт хийсэн. Хяналт шалгалтаар дараах эмнэлгүүдэд илэрсэн зөрчилд төлбөрийн акт тогтоож, ЭМДСан-д төвлөрүүлж барагдуулсан байна. Үүнд:

Хүснэгт №7 ЭМДЕГ-аас хувийн хэвшлийн ЭМБ-д хүргүүлсэн төлбөрийн актын дүн

№	Эрүүл мэндийн байгууллагын нэр	Төлбөрийн актын дүн /сая.төгрөг/	Даатгуулагчийн тоо
1	Эрдэнэт-Ачит нар ХХК	16.5	33
2	ЗБЗ амьдрал бэлэглэгч ХХК	16.3	35
3	Их тавт ХХК	16.4	22
4	Таван талын булаг ХХК	16.2	19
	Нийт дүн	65.4	109

Харин Орхон аймгийн БОЭТ-д дараах төлбөрийн актыг тогтоохоор цахимаар танилцуулж, баримтаар ирүүлсэн ч төлбөрийн актыг баталгаажуулалгүй буцаасан байна.

Хүснэгт №8 ЭМДЕГ-аас БОЭТ-д хийсэн шалгалтаар илэрсэн зөрчлийн дүн

№	Орхон аймгийн БОЭТ	Шалгасан		Акт тогтоох	
		тоо	дүн	тоо	дүн
1	Зүрхний дутмагшил	77	84.4	28	30.2
2	Тархийн судасны цүлхэн	97	47.4	93	45.4
3	Хамрын таславчийн эмгэг	57	63.8	53	62.7
4	Элэгний фиброз ба цирроз	18	47.7	2	5.6
5	Эрсдэлтэй жирэмсний хяналтын багц	177	12.5	107	11.2
6	Эрчимт эмчилгээ	39	178.0	32	158.0
	Нийт дүн	465	433.8	315	313.1

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан 2022 он 32 дугаар “Хяналт шалгалтын удирдамж”-ийн дагуу Орхон аймгийн БОЭТ-ийн ЭМДЕГ-тай байгуулсан “Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг худалдан авах гэрээ”-ний үүргийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийж, гэмтлийн тасагт үений хагалгаа хийлгэсэн 6 даатгуулагчийн хамтын төлбөрийг илүү нэхэмжлэн авсан 9.7 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоосон боловч төлөгдөөгүй Эрүүл мэндийн даатгалын хэлтэс авлага үүсгэсэн байна.

ЭМДҮЗ-ийн 2022 оны 08 дугаар сарын 11-ний 12 дугаар тогтоолоор баталсан Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, төлбөрийн хяналтын журмын 5.3-д “Иргэн, даатгуулагчийн эрүүл мэндийн мэдээллийн нууцлалыг ЭМБ болон ЭМДЕГ адил тэгш хариуцна. ЭМДЕГ болон ЭМБ нь өөрсдийн үйл ажиллагаанд хамаарах программ хангамжийн хөгжүүлэлтийг хариуцаж, шаардлагатай хөгжүүлэлтийг цаг тухайд нь гүйцэтгэнэ” гэж заасныг хангаагүйн улмаас дээрх зөрчил үүссэн байна.

ЭМДЕГ-ын Худалдан авалт гэрээлэлтийн газраас өгсөн чиглэлийн дагуу сонгон шалгаруулалтад оролцсон 9 ЭМБ-д газар дээрх хяналтыг хийж тайланг хүргүүлжээ.

ЭМДЕГ-ын даргаар ахлуулсан удирдлагын баг Орхон аймагт 2022 оны 09 дүгээр сарын 15-ны ажилласан. Энэ үеэр “Эрдэнэт медиал” эмнэлгийн газар дээрх хяналтыг хийж хамтран ажиллах гэрээнд гарын үсэг зурсан байна.

Орон нутгийн ЭМДХ-т шалгалтын баталгаажсан тайланг өгч биелэлтийг хангуулах арга хэмжээ авдаггүйгээс зарим Эрүүл мэндийн байгууллагуудад шалгалтын үр дүн хэрэгжихгүй байна.

Б3.4. Шилэн дансны тухай болон Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт нь ЭМДЕГ-т хамааралтай байна.

Орон нутаг дахь Эрүүл мэндийн даатгалын хэлтэс нь 3 хүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаа явуулж байгаа хэдий ч төсөв санхүү нь ЭМДЕГ-аас санхүүжигдэж байгаа тул шилэн дансанд мэдээлэл тавигдах, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт дээд шатандаа хамаарч байна.

Эрүүл мэндийн даатгалын хэлтэстэй гэрээ байгуулж ажиллаж байгаа БОЭТ 2021 онд 193 мэдээллээс 13 мэдээлэл, 2022 онд 6 мэдээлэл, Жаргалант сумын эрүүл мэндийн төв 2021 онд 14 мэдээлэл, 2022 онд 8 мэдээлэл, Анхны-Оч ӨЭМТ 2011 онд 3 мэдээлэл, Мэнд цэцэн ӨЭМТ 21 онд 1 мэдээлэл, Үйлс бадрах ӨЭМТ 2022 онд 1 мэдээлэл, Учралтбаяр ӨЭМТ 2021 онд 3 мэдээлэл, Мөнх сүндрэл ӨЭМТ 2021 онд 3 мэдээлэл, 2022 онд 2 мэдээлэл, Нийцэл ӨЭМТ 2021 онд 2 мэдээлэл, 2022 онд 1 мэдээлэл, Мөнхийн гэгээ ӨЭМТ 2021 онд 2 мэдээлэл, 2022 онд 1 мэдээлэл, Энхжих мандирваа ӨЭМТ 2021 онд 2 мэдээлэл огт мэдээлээгүй, 1 мэдээлэл тус тус хоцроож мэдээлсэн байна.

Монгол Улсын Ерөнхий аудиторов 2022 оны А/59 дүгээр тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэл”, 2022 оны А/89 дугаар тушаалаар баталсан “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэлийг хэрэгжүүлэх заавар”-ыг газрын хэмжээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж ажилласан.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой санхүүгийн тайлангийн аудитаар 4 байгууллагад 6.6 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 16.6 сая төгрөгийн 4 албан шаардлага өгсөн байна.

Холбогдох байгууллагын санал:



**ОРХОН АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН
ХЭЛТЭС**

Баян-Өндөр сум, Орхон аймаг, 61000

Утас/Факс: (976) 7035 4072,

Цахим шуудан: orkhon@emd.gov.mn,

Цахим хуудас: www.emd.gov.mn

2023-05-19 № 23/51

танай _____-ны № _____-т

**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА
Ц.НАРМАНДАХ ТАНАА**

Төрийн аудитын газраас хийсэн Эрүүл мэндийн даатгалын үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо үр нөлөө хяналт шалгалтын тайлангийн төсөлд оруулах саналгүй болно.

ДАРГА



Д.ЧИМГЭЭ



**ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР**

61049 Орхон аймаг, Баян-Өндөр сум, Уурхайчин баг
Уурхайчны гудамж, Утас: 70350659
Цахим шуудан: orkhon_emg@yahoo.com

2023.05.19 № 02/233
танай _____ -ны № _____ -т

**ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ**

2023 онд танай байгууллагаас хийсэн “Эрүүл мэндийн даатгалын үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөө” сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Эрүүл мэндийн газраас санал, гомдол, хүсэлт байхгүй болно.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.СҮХЭЭ

My doc.Albanbichig A5

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Эрүүл мэндийн даатгалын сангийн 2022 оны орлогыг ЭМДЕГ-аас үндэслэлгүй 18,816.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж баталж, орлогын төлөвлөгөө тасарсан байна.
- Эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ өөрөө хариуцан төлөгч иргэдийн хамралтын төлөвлөгөөний хэрэгжилт хангалтгүй байна.
- Эрүүл мэндийн байгууллагаас ирүүлж буй нэхэмжлэлд цахимаар болон эмч, байцаагчид хяналт хэрэгжүүлж буй боловч алдаа, дутагдал, давхардал гарч байна.
- Нэхэмжлэлийн хяналтаар хасагдсан тохиолдол тус бүрийн дэлгэрэнгүй тайланг эрүүл мэндийн байгууллагуудад сар бүр илгээдэггүй нь ЭМДҮЗ-ийн 2022 оны 12 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Чанар, төлбөрийн хяналтын журам”-ын 4.1.2.3-т заасантай нийцэхгүй байна.
- Баримтыг архивын ажлын үндсэн зааврын дагуу үдэж, архивын нэгж үүсгээгүй, цахим баримт бичиг нь албан ёсны хүчинтэй байх, үнэн зөв байх, бүрэн бүрдэлтэй байх, ашиглах боломжтой баталгаажсан байх шаардлагыг хангахгүй байна.
- Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний талаарх даатгуулагчдын мэдлэг, мэдээлэл дутмаг, хүртээмж хангалтгүй байна.
- Даатгуулагчид үзүүлсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг оношийн хамааралтай бүлгээр нэхэмжлэлийн хяналт хийж байгаа боловч хэвтэн эмчлүүлэхээс өмнө хийлгэсэн байвал хийлгэх оношилгоо, шинжилгээний талаар шалгуур үзүүлэлтийг тодорхойлж гаргаагүй байна.

Аудитаар илэрсэн 65.9 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн 7 акт тогтоож холбогдох байгууллагуудад хүргүүлсэн.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт, нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

Эрүүл мэндийн даатгалын хэлтэст:

- Орлогын төлөвлөгөөг үндэслэлтэй батлуулах, баталсан орлогын төлөвлөгөө болон хамрагдалтын төлөвлөгөөний биелэлтийг хангах талаар арга хэмжээ авч ажиллах.
- Иргэдэд чиглэсэн мэдээллээр хангах үйл ажиллагааг өргөн цар хүрээтэй хүргэж ажиллах.
- Нэхэмжлэлийн хяналтаар хасагдсан тохиолдол тус бүрээр дэлгэрэнгүй тайлан гаргаж эрүүл мэндийн байгууллагад сар бүр хүргүүлж хэвших.
- Баримт материалыг цаг тухай бүрд архивын нэгж болгон бүрэн хадгалах.
- Авлага үүсгэсэн болон давхардуулан санхүүжилт олгосон асуудлын шалтгаан нөхцөлийг тодорхойлж, журмын хүрээнд холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлж, давтан гаргахгүй байх.

САНАЛ: Үндэсний аудитын газарт.

Орон нутгийн лавлагаа шатлалын эмнэлгүүд үзүүлэх боломжтой зарим тусламж үйлчилгээг төрөлжсөн нарийн мэргэжлийн эмнэлэгт үзүүлэхээр хязгаарлалт тогтоож буй ЭМДЕГ-ийн сонгон шалгаруулалтын шаардлагыг бууруулах талаарх Орхон аймаг дахь БОЭТ-ийн саналыг хавсаргав.

ХАВСРАЛТ:

Хавсралт №1

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын 2021, 2022 онд нэхэмжилсэн санхүүжилт болон олгосон санхүүжилтийн тооцоо.

/сая.төгрөг/

Д/д	Байгууллагын нэр	Нэхэмжилсэн дүн		Цахим, программын хяналтаар хасагдсан дүн		Нэхэмжлэхийн хяналтаар хасагдсан дүн		Олгохоор тооцсон санхүүжилт	
		2021	2022	2021	2022	2021	2022	2021	2022
1	БОЭТ	13,664.1	21,067.4	2,664.7	1,799.3	99.4	715.9	10,900.0	18,552.2
	БОЭТ-ийн дүн	13,664.1	21,067.4	2,664.7	1,799.3	99.4	715.9	10,900.0	18,552.2
Хувийн хэвшлийн эмнэлгүүдэд олгосон санхүүжилт									
1	Ачит нар ХХК	509.3	1,028.9	16.6	29.5	4.0	80.7	488.8	918.7
2	Бадархундага рашаан ХХК	979.9	1,243.7	90.9	15.0	35.8	240.9	853.2	987.8
3	Баян-Өндөр мед ХХК	97.2	153.1		0.2		2.3	97.2	150.6
4	ЗБЗ амьдрал бэлэглэгч ХХК	385.4	513.4	1.4	2.6	0.8	64.8	383.2	446.0
5	Их тавт ХХК	198.5	613.1	13.7	32.8	10.6	53.7	174.2	526.6
6	Таван Талын булаг ХХК	698.2	604.5	23.6	11.8	22.9	20.6	651.6	572.1
7	Эрхэст оргил ХХК	293.5	527.8	3.6	4.5	0.4	6.8	289.6	516.5
8	Нейротоп ХХК	836.0	1,232.2	36.0	8.2	6.2	73.4	793.9	1,150.7
9	Очир-Увидас ХХК	455.9	777.7	37.7	14.7	1.0	205.8	417.2	557.2
10	Медикал ХХК	1,634.7	1,620.2	5.4	5.9	1.3	32.1	1,628.0	1,582.2
11	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ - Сувилал		216.6		0.7		0.4	0.0	215.5
	ХХЭ-т олгосон дүн	6,088.7	8,531.2	228.9	125.9	83.0	781.3	5,776.9	7,624.0
Өрх, сумын эрүүл мэндийн төвүүдэд олгосон санхүүжилт									
1	Анхны Оч ӨЭМТ	52.8	865.9	0.0	0.7	1.4	3.5	51.4	861.7
2	Жаргалант СЭМТ	30.5	535.9	0.0	0.9	0.5	2.2	30.0	532.8
3	Мөнхийн гэгээ ӨЭМТ	44.3	453.6	0.0	0.1	3.0	3.9	41.3	449.7
4	Мөнхсүндэрл ӨЭМТ	34.8	542.9	0.0	0.1	2.8	4.1	31.9	538.7
5	Мэндцэцэн ӨЭМТ	73.6	789.7	0.0	0.3	5.7	4.7	67.9	784.6
6	Нийцэл ӨЭМТ	31.5	580.3	0.0	0.7	1.7	4.1	29.8	575.6
7	Учралт баяр ӨЭМТ	41.7	696.4	0.0	0.4	4.2	3.9	37.5	692.1
8	Үйлс бадрах ӨЭМТ	62.9	582.8	0.0	3.4	1.9	4.3	61.0	575.2
9	Энхжих мандирваа ӨЭМТ	41.0	522.7	0.0	0.3	2.9	11.7	38.1	510.8
	ӨСЭМТ дүн	413.1	5,570.2	0.0	6.8	24.1	42.3	389.0	5,521.1
Ковидын тусламж, үйлчилгээ, вакцин, шинжилгээний санхүүжилт									
1	БОЭТ	9,927.6	1,520.4	62.9	60.3	1,151.0	45.0	8,713.7	1,415.1
2	Ачит нар ХХК	2,370.5	817.0	13.1	35.3	210.5	47.3	2,146.8	734.4
3	Бадархундага рашаан ХХК	1,436.6	617.3	20.6	6.3	67.6	34.1	1,348.4	576.9
4	Таван Талын булаг ХХК	1,733.2	553.0	10.7	56.0	307.7	39.9	1,414.8	457.1
5	Баян-Өндөр мед ХХК	1,828.6	1,459.9	22.9	136.4	109.8	71.3	1,695.8	1,252.2
6	Нейротоп ХХК	1,290.0	66.8	0.0	2.2	88.6	2.2	1,201.4	62.5
7	Очир-Увидас ХХК	1,120.3	391.5	27.6	15.1	176.4	20.7	916.3	355.7
8	ӨСЭМТ-үүдийн тусгаарлалт	2,629.3	1,130.2	339.7	57.6	182.9	27.4	2,106.7	1,045.3
9	Ковидын вакцин	699.7	69.2					699.7	69.2
10	Ковидын тандалт, PSR шинжилгээ	1,053.8	358.2					1,053.8	358.2
	Ковидын дүн	24,089.6	6,983.5	497.6	369.2	2,294.6	287.8	21,297.5	6,326.5
1	Эмийн сангуудад олгосон хөнгөлөлттэй эмийн санхүүжилт	2,841.6	3,402.1	0.9	2.8	12.4	7.6	2,828.3	3,391.6
	Эмийн сан дүн	2,841.6	3,402.1	0.9	2.8	12.4	7.6	2,828.3	3,391.6
	Нийт	47,097.1	45,554.4	3,392.1	2,304.0	2,513.4	1,835.0	41,191.6	41,415.4



**ОРХОН АЙМАГ ДАХЬ
БҮСИЙН ОНОШИЛГОО
ЭМЧИЛГЭЭНИЙ ТӨВ**

61029 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Зэст баг, Хантайн гудамж-1, Утас: 70359661
Факс: +97670359661

Цахим шуудан: info@orkhonboet.moh.gov.mn

2023.05.19 № 323
танай _____-ны № _____-т

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ

Хүсэлт хүргүүлэх тухай

Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5 дахь хэсэгт “Эмнэлгийн тусламж, үйлчилгээ нь анхан болон лавлагаа шатлалтай байна” гэж заасан байдаг ба тус төв нь бүс нутгийн хэмжээнд лавлагаа шатлалын тусламж үйлчилгээг үзүүлэн ажилладаг билээ.

ЭМДЕГ-аас сонгон шалгаруулалтыг зарладаг боловч энэ лавлагаа шатлалын эмнэлгүүдийн тэгш, шударга оролцох боломжийг хааж хязгаарладаг. Жишээлбэл Эрчимт эмчилгээний А эрэмбийн өртгийн жин 4,978,000 төгрөг байдаг ба энэ нь хоёроос дээш эрхтний дутагдалтай өвчтөнд хамаарах заалт юм. Бүс нутгийн хэмжээнд тусламж үйлчилгээ үзүүлж байгаа манай төвийн Эрчимт эмчилгээний тасагт хэвтэн эмчлүүлэгчдийн 95% нь хоёроос дээш эрхтний дутагдлаар эмчлэгдэж байна.

2022 онд нийт 257 иргэнд эрчимт эмчилгээний тусламж, үйлчилгээг үзүүлснээс зохиомол амьсгалын аппаратад 103 эмчлүүлэгчийг авч эмчилсэн ба үүний 46 тохиолдол нь зохиомол амьсгалын аппаратаас гарсан ба зохиомол амьсгалын аппараттай дундаж ор хоног 7,5 байсан. Зохиомол амьсгалын аппаратад эмчлүүлэгчийг эрт авч эмчилснээр хоног болоогүй нас баралтыг 6 тохиолдлоор бууруулж, А эрэмбээр тусламж үйлчилгээ үзүүлж байгаа боловч ЭМДЕГ-аас В эрэмбийн буюу 2,067,000 төгрөгөөр санхүүжүүлдэг. Бодит байдал дээр нэг өвчтөний эмчилгээний зардалд 10-15 сая төгрөгийг зарцуулж байна. Мөн яаралтай тусламж авч буй нийт үйлчлүүлэгчийн 20-30% нь А эрэмбийн үйлчлүүлэгч байгаа боловч бодитой санхүүжилт авч чадахгүй байна. Энэ нь санхүүгийн эрсдэлд орох нөхцөл байдлыг үүсгэдэг.

612300687
My doc:/alban toot/A4

Энэ мэт дийлэнх мэс заслын болон эмийн эмчилгээний тусламж үйлчилгээнүүд дээр тусламж үйлчилгээг үзүүлэх хүний нөөц, эм, эмнэлгийн хэрэгсэл, өрөө тасалгаа, тоног төхөөрөмжийн хангалт хангалттай байгаа боловч энэхүү тусламж үйлчилгээг зөвхөн төрөлжсөн нарийн мэргэжлийн эмнэлэгт үзүүлнэ гэх эсвэл бусад жижиг шалтгаануудын улмаас гэрээлэхгүй байна.

Энэ нь манай байгууллагын болон хөдөө орон нутгийн хөгжил, Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах бодлого, иргэдийн орон нутагтаа эмнэлгийн тусламж, үйлчилгээг авах боломжид саад учруулан "Алсын хараа-2050" урт хугацааны хөгжлийн бодлого хэрэгжүүлэх суурь нөхцөлийг бүрдүүлэх "Шинэ сэргэлтийн бодлого"-ын хүрээнд Хот хөдөөгийн сэргэлтийн чиглэлийг эрчимжүүлэхэд тушаа болж байна. Бид энэ асуудлаар ЭМДЕГ-т удаа дараа хандсан боловч шийдвэрлэгдэхгүй удаж байна.

Иймд лавлагаа шатлалын эмнэлгүүдийг сонгон шалгаруулалтад тэгш оролцох боломжоор хангах асуудлыг Төрийн аудитын шалгалтын дүгнэлтэд тусгаж холбогдох газруудад уламжлан бидний үйл ажиллагааг дэмжлэг үзүүлэн ажиллана уу.

ЭМНЭЛЗҮЙ ЭРХЭЛСЭН ДЭД
ЗАХИРАЛ М.АЛТАНБЕК



My doc:/alban toot/A4